

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирлын 2018 оны 13 сарын 13 өдрийн 134 тушаалын 1 дүгээр хавсралт  
VX30172 407499

## МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ДУГУЙЛАНГИЙН СУРАГЧДЫГ УГТАХ ҮДЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн дугуйлангийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөхөөс урьдчилан сэргийлэх, багш, эцэг эх, асран хамгаалагчдыг оролцуулан сурагчдыг гараас гарт хүргэх буюу угтах, үдэх үйлчилгээг зохицуулахад оршино.

1.2. Дугуйлангийн сурагчдыг гараас гарт хүргэх буюу угтах, үдэх үйлчилгээг үзүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Боловсролын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн сургалтын менежер сурагчдыг угтах үдэх үйлчилгээ үзүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангаж, нийгмийн ажилтан, жижүүр багш хяналт тавин, тасралтгүй явагдах нөхцлийг бүрдүүлж ажиллах ба төвийн багш, жижүүр нь сурагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар нэгдсэн ойлголт өгч ажиллана.

2.2. Угтах, үдэх үйлчилгээг хичээлийн өглөөний ээлж /08.30-11.50/, өдрийн ээлж /14.00-16.50/ эхлэх, дуусах цаг тус бүрд төвийн багш нар сурагчдын эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран зохион байгуулна.

2.3. Төвийн багш, жижүүр нь угтах, үдэх үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах бөгөөд дараах үүрэг хүлээнэ.

2.3.1. Төвийн багш өөрийн дугуйлангийн бага ангийн /ЕБС-ийн 1-5 дугаар ангийн/ сурагчдыг хичээл эхлэх үед эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авч, хичээл дуусах үед эцэг эх, асран хамгаалагчид хариуцлагатайгаар хүлээлгэн өгнө. Жижүүр түүнд хяналт тавьж, багшийн эзгүйд угтах, үдэх үйлчилгээг үзүүлнэ.

2.3.2. Дунд болон ахлах ангийн /ЕБС-ийн 6-12 дугаар ангийн/ сурагчдад тогтмол замын хөдөлгөөний аюулгүй байдал болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн эцэг эх, асран хамгаалагчтай нь хамтран ажиллана.

2.3.3. Хэрэв хичээл дуусах цагт бага ангийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагч ирээгүй буюу хоцорч ирэх тохиолдолд сурагчийг ангидаа байлгаж, эцэг эх, асран хамгаалагчтай нь холбоо тогтоож, шаардлага тавина.

2.3.4. Угтах, үдэх үйлчилгээг үзүүлэхдээ сурагчдын эцэг эх, асран хамгаалагчтай зөв боловсон харьцаж, хүүхдийн аюулгүйн байдлыг хангахын төлөө нягт холбоотой ажиллана.



2.3.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төвийн зүгээс болон хууль сахиулах байгууллагаас зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд сурагчдын хамт идэвх санаачилгатай оролцоно.

2.4. Сурагчдын эцэг эх, асран хамгаалагч нь дараах үүрэг хүлээнэ.

2.4.1. Бага ангийн /ЕБС-ийн 1-5 дугаар ангийн/ сурагчдыг хичээл эхлэх үед багшид хүлээлгэн өгч, хичээл дуусах үед багшаас хариуцлагатайгаар хүлээн авна. Эцэг эх, асран хамгаалагч хичээл дууссан цагаас 20 минутын дотор хүүхдийг хүлээн авах үүрэгтэй.

2.4.2. Дунд болон ахлах ангийн /ЕБС-ийн 6-12 дугаар ангийн/ сурагчдын аюулгүй байдалд хяналт тавьж, багш нартай хамтран ажиллана.

2.4.3. Угтах, үдэх үйлчилгээний үед төвийн багш, жижүүртэй хүндэтгэлтэй харьцаж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар байгууллагын зүгээс тавьсан шаардлагыг биелүүлнэ. Хичээл эхлэх болон дуусах үед хоцорч ирэх буюу ирж чадахгүй болсон тохиолдолд багшид нэн даруй мэдэгдэж, хүүхдийг хичээлээс авах хүний мэдээллийг өгөх үүрэг хүлээнэ.

2.4.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төвийн зүгээс болон хууль сахиулах байгууллагаас зохион байгуулж буй ажил, арга хэмжээнд хүүхдийн хамт идэвх санаачилгатай оролцоно.

2.5. Төвийн багш, албан хаагчид болон сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид төвийн ойр орчимд гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан тохиолдолд мэдээллийг төвийн удирдлага болон цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлнэ.

2.6. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага төвийн удирдлагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэлд шуурхай үүрэг гүйцэтгэж ажиллана.

### **Гурав. Бусад зүйл, хариуцлага**

3.1. Багш, жижүүрийн анхаарал болгоомжгүй, хайхрамжгүй байдлаас үүдэн бага ангийн сурагчийг танихгүй хүнд өгч явуулах, эцэг эх, асран хамгаалагчийн гарт хүлээлгэн өгөөгүйгээс хүүхдийн эрүүл мэнд, амь насанд хохирол учирсан тохиолдолд холбогдох ажилтанд хариуцлага хүлээлгэнэ.

3.2. Сурагчийн эцэг эх, асран хамгаалагч хүүхдийн талаар багшид худал мэдээлэх, санамж бичигт заасны дагуу үүргээ биелүүлээгүй буюу хүүхдийг багшийн гарт нь хүлээлгэж өгөөгүйн улмаас хүүхдийн эрүүл мэнд, амь насанд хохирол учирсан тохиолдолд багш, албан хаагчид хариуцлага хүлээхгүй болно.

3.3. Сурагчийн эцэг эх, асран хамгаалагч тогтсон хугацаанд ирээгүй буюу багшид шаардлагатай мэдээллийг өгөөгүйгээс хүүхэд хараа хяналтгүй гэмтэж бэртэн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд төвийн багш, албан хаагчид хариуцлага хүлээхгүй болно.